



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ
2013 оны

9 дүгээр

Улаанбаатар

сарын 21-ний өдөр
322

Дугаар
хот

ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ

“Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-ний 274.8 дахь арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Захиргааны байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний нийтлэг журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.
2. Энэхүү журмыг үндэслэн эрхэлсэн салбар, орон нутгийн онцлогт нийцсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний аргачлалыг боловсруулан баталж, мөрдүүлэхийг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлаг болон аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.
3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Журам батлах тухай” Засгийн газрын 2006 оны 160, “Журамд нэмэлт оруулах тухай” 2009 оны 285, “Журам шинэчлэн батлах тухай” 2010 оны 11 дүгээр тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

Монгол Улсын Ерөнхий сайд

Н.АЛТАНХУЯГ

Монгол Улсын сайд,

Засгийн газрын Хэрэг

эрхлэх газрын дарга

Ч.САЙХАНБИЛЭГ

ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГЫН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ НИЙТЛЭГ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Энэхүү журмыг захиргааны байгууллагын үйл ажиллагаа, Монгол Улсын хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж, Засгийн газрын шийдвэр (цаашид “Холбогдох эрх зүйн акт” гэх), бодлогын баримт бичгээр Засгийн газарт үүрэг, чиглэл өгсөн заалт, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах, тайлагнах болон тэдгээрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж, үр дүнг үнэлэхэд мөрдөнө.

2. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго нь Засгийн газрын бодлого, үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлж, хариуцлагыг бэхжүүлснээр Засгийн газарт итгэх иргэдийн итгэлийг нэмэгдүүлэх, төрийн удирдлагын төлөвлөлт, хэрэгжилтийг сайжруулахад оршино.

3. Хяналт-шинжилгээ, үнэлгээний (ХШҮ) үйл ажиллагааг Монгол Улсын Үндсэн хууль, Засгийн газрын тухай хууль, Төсвийн тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомж, энэхүү журмын дагуу хэрэгжүүлнэ.

4. Яам, Засгийн газрын агентлаг, аймаг, нийслэлийн Засаг дарга, Засаг даргын Тамгын газар, улсын төсөвт байгууллага болон төрийн өмчит хуулийн этгээд нь (цаашид “Захиргааны байгууллага” гэх) энэхүү журмын 2 дугаар зүйлд заасан зорилгын хүрээнд дараахь зорилтуудыг хэрэгжүүлнэ. Үүнд:

4.1. Холбогдох эрх зүйн актын хэрэгжилт, тэдгээрийн дунд болон урт хугацааны зорилт нь төлөвлөсөн үр дүнд хүрсэн эсэхэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үр нөлөөг тооцох;

4.2. Төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага нь эрхлэх асуудлын хүрээний болон харьяа байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, төлөвлөлт, гүйцэтгэл, дунд болон урт хугацааны үр дүн, үр нөлөөг сайжруулах;

4.3. Хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан, дүгнэлтэд үндэслэн Засгийн газар, сайд, төрийн захиргааны бусад байгууллагаас гаргах шийдвэр, бодлогын хувилбар, санал, зөвлөмж боловсруулж, Засгийн газар, сайд, агентлагийн дарга,

Засаг дарга болон холбогдох байгууллагын удирдлагад бодлогын дэмжлэг үзүүлэх;

4.4. Төрийн захиргааны бүх шатны байгууллагын ХШҮ-ний тогтолцоог бэхжүүлж, хяналт-шинжилгээ, үнэлгээний стратеги, бодлогыг тодорхойлон, хяналт-шинжилгээ, үнэлгээний удирдлага, арга зүйгээр хангах;

4.5. Засгийн газрын ХШҮ-ний мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлж, шийдвэр гаргахад шаардлагатай мэдээллээр хангах.

Хоёр. Нэр томъёоны тодорхойлолт

5. Энэхүү журамд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно. Үүнд:

5.1. “Бодлогын баримт бичиг” гэдэгт Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх Үндсэн чиглэл, үндэсний хөтөлбөр, төслийн баримт бичгийг;

5.2. “Холбогдох эрх зүйн акт” гэж тухайн салбар болон байгууллагын эрхлэх асуудал, эрх хэмжээний хүрээний асуудлаар үүрэг, даалгавар, чиглэл өгсөн Улсын Их Хурлын тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж, Засгийн газрын тогтоол, Ерөнхий сайдын захирамж, Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийг;

5.3. “Үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ” гэж байгууллагын үйл ажиллагаа болон холбогдох эрх зүйн акт, бодлогын зорилтын хэрэгжилтийн явцыг урьдчилан тодорхойлсон шалгуур үзүүлэлтийн дагуу хянаж, судалгаа, мэдээллийг үндэслэн задлан шинжилж, үр дүнг сайжруулах талаар удирдлага болон оролцогч талуудад мэдээлэх тасралтгүй үйл ажиллагааг;

5.4. “Үр дүнд суурилсан үнэлгээ” гэж байгууллагын үйл ажиллагаа болон холбогдох эрх зүйн акт, хэрэгжиж байгаа болон хэрэгжиж дууссан хөгжлийн бодлогын баримт бичгийн зорилго, зорилтыг хэрэгжүүлснээр төлөвлөсөн зорилтот түвшинд хүрсэн эсэхийг үнэлж, түүний үр дүн, үр ашиг, үр нөлөөг тодорхойлж, цаашид боловсронгуй болгох, сайжруулах чиглэлээр дүгнэлт, зөвлөмж гаргах үйл ажиллагааг;

5.5. “Үр дүнд суурилсан явцын үнэлгээ” гэж байгууллагын үйл ажиллагаа болон холбогдох эрх зүйн акт, бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үе шат бүрт болон дунд хугацаанд зорилтот түвшинд хүрсэн эсэхэд үнэлгээ хийж дүгнэлт, зөвлөмж гаргах үйл ажиллагааг;

5.6. “Үр дүнд суурилсан нэгтгэн дүгнэх үнэлгээ” гэж үйл ажиллагааны жилийн тайлан болон хэрэгжиж дууссан тодорхой бодлого, хөтөлбөр, төсөл нь зорилтот түвшинд хүрсэн эсэхэд эцсийн байдлаар үнэлж, үр дүн, үр ашиг, үр нөлөөг тодорхойлон, цаашид тухайн чиглэлээр бодлого боловсруулан хэрэгжүүлэх эсхүл зогсоох чиглэлээр дүгнэлт, зөвлөмж гаргах үйл ажиллагааг;

5.7. “Хамтарсан үнэлгээ” гэж хэд хэдэн байгууллага хамтран хэрэгжүүлэх шийдвэр, салбар дундын бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хэрэгжүүлэгч байгууллагууд хамтран хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт, зөвлөмж гаргах үйл ажиллагааг;

5.8. “Хөндлөнгийн үнэлгээ” гэж төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагын, мөн бодлогын баримт бичгийн хэрэгжилт, үр дүнд хөндлөнгийн мэргэжлийн байгууллага, судлаач, үнэлгээчдийн хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээг;

5.9. “Өөрийн үнэлгээ” гэж холбогдох эрх зүйн акт, хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэгч захиргааны байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгж нь өөрийн үйл ажиллагаа, бодлогын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, дүгнэлт, зөвлөмж гаргах үйл ажиллагааг;

5.10. “Суурь үзүүлэлт” гэж үйл ажиллагаа болон хөгжлийн бодлого, хөтөлбөр, төсөл хэрэгжиж эхлэх үеийн чанарын болон тоон үзүүлэлтүүдийг;

5.11. “Шалгуур үзүүлэлт” гэж хөгжлийн бодлого, хөтөлбөр, төслийг хэрэгжүүлснээр түүний үе шат бүрт бий болох үр дүн, үр нөлөө, өөрчлөлтийг хэмжихээр урьдчилан тогтоосон чанарын болон тоон үзүүлэлтүүд, тэдгээрийг хэмжих хэмжүүрийг;

5.12. “Зорилтот түвшин” гэж хөгжлийн бодлого, хөтөлбөр, төсөл хэрэгжих үе шатны болон хэрэгжиж дуусах үед хүрэхээр хүлээгдэж байгаа үр дүн, үр нөлөөг урьдчилан тодорхойлсон чанарын болон тоон үзүүлэлт, тэдгээрийг хэмжих хэмжүүрийг;

5.13. “Гүйцэтгэл сайжруулах төлөвлөгөө” гэж байгууллагын тухайн жилийн үйл ажиллагааны ХШҮ-ний тайланг дээд шатны байгууллагаас хянан, дүгнэж гаргасан зөвлөмж, чиглэлийн дагуу дараа онд тухайн байгууллагаас үйл ажиллагаагаа сайжруулах чиглэлээр гаргасан ажлын төлөвлөгөөг;

5.14. “Эрсдэлийн удирдлага” гэж байгууллагын тогтвортой хөгжлийг хангах болон өөрийн чиг үүргийг хэрэгжүүлэхэд учирч болохуйц хор уршигтай үр дагаварыг зөв тодорхойлж, урьдчилан сэргийлэх буюу бууруулахад чиглэсэн цогц арга хэмжээг ойлгоно.

Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зарчим, хамрах хүрээ

6. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зарчим:

6.1. Шударга, хөндлөнгийн нөлөөнөөс хараат бус байх;

6.2. Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх байгууллагын үйл ажиллагаа, тэдгээрээс гаргасан тайлан, дүгнэлт ил тод байх;

6.3. Хяналт-шинжилгээ, үнэлгээ нь тоо баримт, судалгаа, мэдээлэлд үндэслэсэн, тухайн бодлого, хөтөлбөр, төслийн үр дүн, үр ашиг, үр нөлөөг тодорхойлсон, хэмжигдэхүйц, нотлогдохуйц байх;

6.4. Хяналт-шинжилгээг тасралтгүй, үнэлгээг тогтмол, тодорхой үе шаттай хийдэг байх;

6.5. Хяналт-шинжилгээ, үнэлгээнд хэрэглэгч, сонирхогч талуудын оролцоог хангасан байх.

7. Хяналт-шинжилгээ, үнэлгээний хамрах хүрээ:

7.1. Улсын Их Хурал, Засгийн газар, яам, Засгийн газрын агентлагаас гаргасан нийтээр дагаж мөрдөх эрх зүйн акт;

7.2. Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл болон Улсын Их Хурал, Засгийн газар, сайдын эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлэхээр батлан гаргасан бодлогын баримт бичиг;

7.3. Монгол Улсын Ерөнхийлөгчөөс Засгийн газарт чиглэл өгсөн зарлиг;

7.4. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж;

7.5. Нутгийн өөрөө удирдах байгууллагаас баталсан хөгжлийн бодлогын баримт бичиг болон Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл;

7.6. Бүх шатны Засаг даргаас тухайн орон нутагт нийтээр дагаж мөрдүүлэхээр гаргасан бодлого, шийдвэр;

7.7. Засгийн газар, Засгийн газрын гишүүн, аймаг, нийслэлийн нутгийн өөрөө удирдах байгууллага, Засаг даргаас гадаад, дотоодын бусад хуулийн этгээдтэй байгуулсан, хоёр тал харилцан үүрэг хүлээсэн гэрээ;

7.8. Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө, гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа хөтөлбөр, төсөл.

**Дөрөв. Эрх зүйн баримт бичгийг хэрэгжүүлэх ажлыг
зохион байгуулах, мэдээлэх, тайлагнах, ХШҮ-ний мэдээллийн
нэгдсэн санг бүрдүүлэх**

8. Холбогдох эрх зүйн актын хэрэгжилтэд хяналт тавих, мэдээлэх үүргийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газар хариуцна. Энэ үүргийг төрийн захиргааны төв байгууллагад сайд, төрийн захиргааны байгууллагад дарга, нутгийн захиргааны байгууллагад бүх шатны Засаг дарга, байгууллага, улсын төсөвт байгууллага болон төрийн өмчит хуулийн этгээдэд тэдгээрийн дарга (захирал) нар тус тус хариуцна.

9. Засгийн газрын Хэрэг эрхлэх газар нь холбогдох эрх зүйн акт болон бодлогын баримт бичгийг төрийн захиргааны болон нутгийн захиргааны байгууллагад хүргүүлэх ажлыг зохион байгуулна.

10. Захиргааны байгууллага нь холбогдох эрх зүйн акт болон бодлогын баримт бичгийг хэрэгжүүлж, гүйцэтгэл, үр дүнг энэ журмын 1 дүгээр хавсралтад заасан хугацаанд тайлагнаж, мэдээлэх үүрэгтэй.

11. Улсын төсөвт байгууллага болон төрийн өмчит хуулийн этгээд нь холбогдох эрх зүйн акт болон бодлогын баримт бичиг, тэдгээрт нийцүүлэн гаргасан эрх зүйн бусад актын биелэлтийг зохион байгуулж хэрэгжүүлэх бөгөөд хэрхэн хэрэгжүүлж байгааг төрийн захиргааны болон нутгийн захиргааны байгууллага хянана.

12. Шаардлагатай гэж үзвэл төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага эрх зүйн акт болон бодлогын баримт бичгийн зорилтыг агуулга, чиглэлээр нь багцлан хэрэгжилтэд нь хяналт-шинжилгээ хийж, холбогдох арга хэмжээг авч болно.

13. Шаардлагатай гэж үзвэл дээд шатны байгууллага нь холбогдох эрх зүйн акт болон бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг газар дээр нь шалгаж, тайлан, мэдээллийг нь хэлэлцэн, тэдгээрийн мөрөөр холбогдох арга хэмжээг авна.

14. Яам, аймаг, нийслэлийн Засаг дарга цаг хугацааны хувьд ач холбогдолгүй болсон, бодит шалтгааны улмаас хэрэгжих боломжгүй, тухайн асуудлаар дахин шийдвэр гарсан зэрэг тохиолдолд уг шийдвэр, заалтыг хүчингүй болгох тухай

санал, шалтгаан нөхцөлийг нь тодорхой дурдсан жагсаалтыг холбогдох эрх зүйн актын хэрэгжилтийн жилийн эцсийн тайлангийн хамт Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт ирүүлнэ.

15. Засгийн газрын Хэрэг эрхлэх газар саналыг судлан, хяналтаас хасах эсэхийг шийдвэр, заалт бүрээр авч үзэн, Засгийн газрын хуралдаанд оруулан шийдвэрлүүлж, санал ирүүлсэн байгууллагад дараа оны II улиралд багтаан мэдэгдэнэ.

16. Бүрэн хэрэгжсэн, хэрэгжилт нь тогтмолжсон заалтын биелэлтийг дараа улирлаас эхлэн тайланд тусгахгүй бөгөөд тайлангаас хассан заалтын хувийг тухайн жилийн эцсийн нийт дүнд оруулан тооцно.

17. Яам, Засгийн газрын агентлаг, аймаг, нийслэлийн Засаг дарга нь Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогын хэрэгжилтийг энэ журмын 5 дугаар, холбогдох эрх зүйн актын хэрэгжилтийн тайланг 6 дугаар, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг 7 дугаар, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлтийг 8 дугаар, Үндэсний хөтөлбөр, төслийн хэрэгжилтийн тайланг 9 дүгээр хавсралтын дагуу тус тус гаргаж энэ журмын 1 дүгээр хавсралтад заасан хугацаанд холбогдох байгууллагад хүргүүлнэ.

18. Яам, Засгийн газрын агентлаг, аймаг, нийслэлийн Засаг дарга нь Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого, МУ-ын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлтийн тайланг Эдийн засгийн хөгжлийн яаманд, үндэсний хөтөлбөр, төслийн биелэлтийн тайланг тухайн хөтөлбөр, төсөл хэрэгжиж байгаа салбарын яаманд хүргүүлэх бөгөөд яам нь тайланг нэгтгэн, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүнг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ.

19. Засгийн газрын Хэрэг эрхлэх газар нь Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогын хэрэгжилтийг танилцуулахаар, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлтийн тайланг өргөн мэдүүлэхээр хууль болон бодлогын баримт бичигт заасан хугацаанд багтаан УИХ-д тус тус хүргүүлнэ.

20. Засгийн газрын Хэрэг эрхлэх газар УИХ-ын тогтоолын биелэлтийн нэгдсэн дүнг УИХ-ын Тамгын газарт, Ерөнхийлөгчийн зарлигаар Засгийн газарт чиглэл өгсөн заалтын биелэлтийн дүнг Ерөнхийлөгчийн Тамгын газарт, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмжийн биелэлтийн дүнг Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын албанд оны эхний хагас жил болон жилийн эцсийн байдлаар гарган хүргүүлнэ.

21. Засгийн газрын Хэрэг эрхлэх газар нь холбогдох эрх зүйн акт болон бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн дүнгийн талаар Засгийн газраас гаргасан шийдвэрийг захиргааны байгууллагад тухай бүр мэдэгдэх бөгөөд тэдгээр

байгууллагууд шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг салбар, орон нутагт зохион байгуулж ажиллана.

22. Яам, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын тухайн жилийн үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан нь дараах хавсралттай байна. Үүнд:

Яам:

-Төсвийн ерөнхийлөн захирагчаас төсвийн шууд захирагчтай байгуулсан гэрээний биелэлт;

-Тухайн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт;

-Гүйцэтгэл сайжруулах төлөвлөгөөний биелэлт;

-Байгууллагын ил тод байдлын үнэлгээний тайлан;

-Байгууллагын шударга байдлын үнэлгээ (АТГ гаргана);

-Засаглалын болон эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн биелэлт;
-Хэрэглэгчийн үнэлгээний тайлан.

Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар:

-Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлт;

-МУ-ын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт;

-Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлт;

-Төсвийн ерөнхийлөн захирагчаас төсвийн шууд захирагчтай байгуулсан үр дүнгийн гэрээний биелэлт;

-Сайдаас аймаг, нийслэлийн Засаг даргатай байгуулсан гэрээний үүргийн биелэлт (Яам гаргана);

-Гүйцэтгэл сайжруулах төлөвлөгөөний биелэлт;

-Байгууллагын ил тод байдлын үнэлгээний тайлан;

-Байгууллагын шударга байдлын үнэлгээ (АТГ гаргана);

-Засаглалын болон эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн биелэлт;

-Хэрэглэгчийн үнэлгээний тайлан.

23. Энэ журмын 1 дүгээр хавсралтын дагуу урьд нь холбогдох байгууллагад хүргүүлсэн тайланг яам, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын тухайн жилийн үйл ажиллагааны хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлангийн хавсралтаар дахин ирүүлэхгүй.

24. Тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээгээр тогтоогдсон байдал, холбогдох тоо баримт, санал, дүгнэлтийг тусгасан байхаас гадна шаардлагатай бол зураг, дүрс бичлэг хавсаргаж болох бөгөөд яамны Төрийн нарийн бичгийн дарга, Засаг даргын Тамгын газрын болон Хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгжийн дарга гарын үсэг зурж баталгаажуулсан байна.

25. Яам, Засгийн газрын агентлаг, аймаг, нийслэлийн Засаг дарга нь холбогдох эрх зүйн акт болон бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг гаргахдаа дараах журмыг баримтална:

25.1. Холбогдох эрх зүйн акт болон бодлогын баримт бичгийг хяналтад авах, биелэлтийг тайлагнахдаа огноогоор бус, хамаарах салбар, чиглэлээр ангилсан байна;

25.2. Хэд хэдэн Засгийн газрын гишүүн, аймаг, нийслэлийн Засаг дарга, байгууллагад өгсөн үүрэг, даалгавар, зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг эхэнд нэр нь бичигдсэн Засгийн газрын гишүүн, агентлагийн дарга, Засаг дарга толгойлон зохион байгуулж, хэрэгжилтийг нэгтгэн мэдээлнэ;

25.3. Бодлогын баримт бичиг баталсан шийдвэрийн хэрэгжилтийг “Холбогдох эрх зүйн актын биелэлтийн тайлан”-д давхар тусгахгүй бөгөөд тухайн чиглэлээр гарсан бусад баримт бичгийн хэрэгжилттэй уялдуулан нэгтгэж тайлагнаж болно;

25.4. Холбогдох эрх зүйн актын 4-өөс дээш жил хэрэгжүүлж байгаа заалт эсхүл нийт төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага хэрэгжүүлэхээр заасан заалтын хэрэгжилтийг тайлагнахдаа урт, дунд хугацаанд бий болсон үр нөлөөг тооцож, цаашид авах арга хэмжээ, хяналтаас хасах тухай санал зэрэг асуудлыг тусгана.

26. Захиргааны байгууллага нь холбогдох эрх зүйн акт болон бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн албан ёсны тайлан, мэдээллийн урсгалыг цэгцтэй, хялбар болгох, хянах, хадгалалт, ашиглалтыг сайжруулах, тэдгээрт хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд “Засгийн газрын ХШҮ-ний мэдээллийн нэгдсэн систем”-ийг ашиглана.

27. Засгийн газрын Хэрэг эрхлэх газар “Засгийн газрын ХШҮ-ний мэдээллийн нэгдсэн системийг ашиглах заавар”-ыг баталж, уг системийг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангаж ажиллана.

Тав. Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх байгууллагын үйл ажиллагаа

28. Засгийн газрын Хэрэг эрхлэх газар нь дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

28.1. Холбогдох эрх зүйн актын хэрэгжилт, тэдгээрийн үр дүнд хяналт-шинжилгээ хийж, үнэлгээ өгөх, холбогдох байгууллагад тайлагнах;

28.2. Яам, Засгийн газрын агентлаг, аймаг, нийслэлийн Засаг даргын үйл ажиллагаанд үнэлгээ өгч, дүнг Засгийн газрын хуралдаанд танилцуулах;

28.3. Захиргааны байгууллагын ХШҮ-ний бодлого, стратегийг тодорхойлж, бүтэц, тогтолцоог бэхжүүлэх, хүний нөөцийн чадавхийг сайжруулах асуудлыг нэгдсэн удирдлагаар хангаж, мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулах;

28.4. Яам, аймаг, нийслэлийн засаглалын болон эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийг батлуулах ажлыг зохион байгуулах;

28.5. Холбогдох эрх зүйн акт болон бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгдсэн дүнг Засгийн газрын хуралдаанд оруулах.

29. Яам, Засгийн газрын агентлаг, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар нь дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

29.1. Холбогдох эрх зүйн актын хэрэгжилт, тэдгээрийн үр дүнд хяналт-шинжилгээ хийж, үнэлгээ өгөх, холбогдох байгууллагад тайлагнах;

29.2. Яам нь эрхлэх асуудлын хүрээний Засгийн газрын агентлаг, улсын төсөвт байгууллага, төрийн өмчит хуулийн этгээдийн, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар Засаг даргын дэргэдэх агентлаг, сум, дүүргийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж, үнэлгээ өгөх;

29.3. Харьяа байгууллагын зорилт, үйл ажиллагааны суурь болон шалгуур үзүүлэлт, хүрэх түвшинг батлах;

29.4. Салбарын болон орон нутгийн хэмжээнд шийдвэр гаргах, бодлого боловсруулах, хэрэгжүүлэхэд оролцож байгаа байгууллагыг мэдээллээр хангах, тэдгээрийн үйл ажиллагааг сайжруулахад чиглэсэн сургалт зохион байгуулах, зөвлөгөө, дэмжлэгээр хангах;

29.5. Засгийн газар болон бусад холбогдох байгууллагыг шаардлагатай мэдээ, мэдээллээр хангах;

29.6. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүнд үндэслэн санал боловсруулж, холбогдох байгууллагад уламжлан шийдвэрлүүлэх;

29.7. Байгууллагын өөрийн хяналт-шинжилгээ, үнэлгээг жил бүр хийх.

30. Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын хэсэг:

30.1. Харьяа байгууллагын үйл ажиллагаанд үнэлгээ өгөх ажлын хэсгийг сайд, аймаг, нийслэлийн Засаг даргын захирамжаар байгуулах бөгөөд энэхүү ажлын хэсгийн 20 хүртэлх хувийг ХШҮ-ний чиглэлээр мэргэшсэн судлаачид, мэргэжлийн байгууллагын төлөөллөөс бүрдүүлж болно;

30.2. Ажлын хэсгийн ажиллах хэлбэр нь хуралдаан байна. Хуралдаанаас тэмдэглэл гаргах бөгөөд уг тэмдэглэлд хуралдаанд оролцогчид, гишүүдийн ирц, хэлэлцэх асуудлын агуулга, асуудлыг хэлэлцсэн явц болон хуралдаанаас гаргасан шийдвэрийг тус тус тусган, хуралдаанд оролцсон гишүүдийн гарын үсгийг зурж баталгаажуулна;

30.3. Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, яам, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын ХШҮ-ний нэгж нь Ажлын хэсгийн хуралдааны товыг Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын хэсгийн ахлагчийн товлосноор зарлах бөгөөд хуралдаанаар хэлэлцэх асуудлыг бэлтгэх, ажлын хэсгийн гишүүдэд хуралдаан болох өдрөөс ажлын 2 хоногийн өмнө хүргүүлэх, хуралдааныг зохион байгуулах арга хэмжээг авна;

30.4. Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын хэсгийн хурлыг нийт гишүүдийн дийлэнх олонхи оролцсон тохиолдолд хүчинтэйд тооцож, ердийн олонхийн саналаар шийдвэр гаргана.

Зургаа. Үнэлгээний төрөл, төлөвлөлт

31. Захиргааны байгууллага нь зорилгоосоо хамааран урьдчилсан, явцын болон нэгтгэн дүгнэх гэсэн 3 төрлийн үнэлгээ хийх бөгөөд хэрэгжүүлэгч байгууллага нь ХШҮ-ний нэгжийн төлөвлөгөөнд ямар төрлийн үнэлгээ хийхийг нарийвчлан тусгана.

32. Урьдчилсан үнэлгээгээр нийгэм, эдийн засгийн тэргүүлэх болон олон нийтийн анхаарал татсан бодлого, хөтөлбөр, төслийг тусгайлан сонгож түүнийг батлан хэрэгжүүлэх нөхцөлд хүлээгдэж байгаа үр дүнг үнэлж, шийдвэр гаргагчид зөвлөгөө өгөхөд чиглэнэ.

33. Явцын болон нэгтгэн дүгнэх үнэлгээ нь хууль тогтоомж, бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн явц, үр дүн, үр нөлөөг тогтооход чиглэнэ.

34. Байгууллагын хууль тогтоомжоор тогтоосон чиг үүргийн хэрэгжилтийг үнэлэх зорилгоор системчилсэн үнэлгээ хийж болно.

35. Эрсдэлийн үнэлгээний зорилго нь захиргааны байгууллагын үнэ цэнийг нэмэгдүүлж, удирдлагын үйл явцын үр нөлөөг үнэлж, сайжруулахад оршино. Хөгжлийн бодлого, хөтөлбөр, төслийн хэрэгжилтийн эрсдэлийн үнэлгээгээр байгууллагын тухайн жилийн болон дунд, урт хугацаанд хэрэгжүүлэхээр дэвшүүлсэн зорилт, үйл ажиллагаа нь улсын урт болон дунд хугацааны бодлогын баримт бичигтэй уялдсан эсэх, тэдгээрийг хэрэгжүүлэх бодит нөөц, боломж, санхүүгийн эх үүсвэр байгаа эсэхийг тодорхойлно.

36. Төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага нь үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө, жилийн үйл ажиллагааны болон хяналт-шинжилгээ, үнэлгээний төлөвлөгөөг жил бүрийн 3 дугаар сарын 1-нээс өмнө батлан “Засгийн газрын ХШҮ-ний мэдээллийн нэгдсэн систем”-д байршуулна.

37. ХШҮ-ний төлөвлөгөөнд тухайн ажлын зорилго, зорилт, хамрагдах байгууллага, хэрэгжүүлэх хугацаа, зардал, оролцох байгууллага зэргийг тусгана. ХШҮ-ний төлөвлөгөө нь байгууллагын алсын хараа, эрхэм зорилгод нийцсэн бодлогын зорилтын дунд болон урт хугацааны үр дүнг тодорхойлсон байна.

Долоо. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үзүүлэлтүүд

38. Төрийн захиргааны төв байгууллага нь эрхлэх асуудлын хүрээний “Засаглалын болон эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт”-ийг Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр батлагдсанаас хойш 3 сарын хугацаанд багтаан бүрэн эрхийн хугацаагаар тооцон Засгийн газрын Хэрэг эрхлэх газартай зөвшилцөн боловсруулж Засгийн газраар батлуулна.

39. Нутгийн захиргааны байгууллага нь “Засаглалын болон эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт”-ийг аймаг, нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр батлагдсанаас хойш 3 сарын дотор бүрэн эрхийн хугацаагаар тооцон тухайн аймаг, нийслэлийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн онцлогийг харгалзан боловсруулж Засгийн газрын Хэрэг эрхлэх газраар батлуулна.

40. Тодорхой бодлогын баримт бичгийг боловсруулан батлахдаа зорилт бүрийн суурь болон шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин, үр дүнг тодорхой тусгаж батална.

41. Бодлогын зорилтын суурь болон шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин, үр дүн, үр нөлөөг тоон үзүүлэлтээр тогтооно. Тоон үзүүлэлт тогтоох боломжгүй бол чанарын шалгуур үзүүлэлтийг аль болох тодорхой тогтооно.

42. Тухайн үйл ажиллагаа болон бодлого хэрэгжиж эхлэх жилийн улсын статистик мэдээллээр гаргасан үзүүлэлт, төрийн байгууллагаас албан ёсоор гаргаж нийтэд мэдээлсэн тоон мэдээ зэргийг суурь үзүүлэлт болгон авна.

43. Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, үр дүнд хийх хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтийг тухайн бодлого, хөтөлбөр, төслийн суурь үзүүлэлт, зорилтот түвшин, хүрэх үр дүнг үндэслэн тогтооно.

44. Шалгуур үзүүлэлт нь дараах шаардлагыг хангасан байна:

-Хамааралтай	буюу	ач	холбогдолтой	байх;
-Урт	хугацаанд	хэрэглэгдэх,	тогтмол	байх;
-Хэрэглэхэд		хялбар,	боломжтой	байх;

-Аль болох богино хугацаанд өөрчлөлтийг илэрхийлэхээр байх.

45. Хөгжлийн бодлого, хөтөлбөр, төслийн хэрэгжилтийн тодорхой үе шатны болон хэрэгжиж дуусах үеийн зорилтот түвшинг суурь үзүүлэлтэд үндэслэн улсын төсөв, гадаад, дотоодын хөрөнгө оруулалт, зээл, тусламж болон нийгэм, эдийн засаг, зах зээлийн гадаад, дотоод хүчин зүйл, улс төрийн өөрчлөлтийн байдал, иргэд, олон нийтийн хандлага зэрэг олон талын боломж, эрсдэлийг урьдчилан тооцож, бодитой, хэрэгжихүйцээр тодорхойлно.

Найм. Хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй

46. Засгийн газрын Хэрэг эрхлэх газар болон яамны хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгжийн төлөөлөл бүхий баг жилд 7-гоос доошгүй аймгийн Засаг даргын Тамгын газар, 5-аас доошгүй яам, агентлагийн үйл ажиллагаанд газар дээр нь хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх бөгөөд үнэлгээний дүнг Засгийн газарт танилцуулна.

47. Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлын хүрээ, хугацааг удирдамжаар тодорхойлно.

48. Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлын удирдамжийг сайд эсхүл яамны Төрийн нарийн бичгийн дарга, Засгийн газрын агентлагийн дарга, Засаг дарга батална.

49. Хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланд тусгасан тоон болон тоогоор илэрхийлж болох зарим үзүүлэлтийг статистикийн болон тухайн үйл ажиллагааны хүрээний асуудлыг хариуцсан бусад байгууллагын судалгааны үзүүлэлт, тухайн жилд Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас яам, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагаанд газар дээр нь хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүн зэрэгтэй харьцуулан нягталж үзнэ.

50. Тайланд хяналт-шинжилгээ хийхдээ баримт бичиг судлах, холбогдох мэргэжилтнүүдтэй ярилцах, санал асуулга явуулах, ажлын бодит гүйцэтгэлийг газар дээр нь шалгах зэрэг дүн шинжилгээний түгээмэл аргуудыг хэрэглэнэ.

51. Яам, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын тухайн жилийн үнэлгээний дүнг энэ журмын 2, 3 дугаар хавсралтын дагуу гаргана.

52. Яам, Засгийн газрын агентлаг, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны үр дүнгийн ерөнхий үнэлгээ нь үзүүлэлт бүрийн хэрэгжилтийн түвшин (хувь)-ий нийлбэрийг нийт үзүүлэлтийн тоонд хувааж гаргасан дундаж хувиар илэрхийлэгдэнэ.

53. Холбогдох эрх зүйн актын биелэлтийн ерөнхий хувийг нийт заалтын биелэлтийн дундаж хувиар тооцно.

54. Төсвийн ерөнхийлөн захирагчаас төсвийн шууд захирагчтай тухайн онд байгуулсан гэрээний биелэлтийг Төсвийн ерөнхийлөн захирагчаас гэрээг дүгнэсэн хувиар тодорхойлно.

55. Сайд бүр аймаг, нийслэлийн Засаг даргатай байгуулсан тухайн жилийн үр дүнгийн гэрээний биелэлтийн үнэлгээг гаргаж 4 дүгээр сарын 1-ний дотор Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт ирүүлнэ.

56. Үйл ажиллагааны ил тод байдлын үнэлгээг Засгийн газраас баталсан төрийн болон нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагааны “Ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлт”-ийн дагуу хийнэ.

57. Салбарын болон аймаг, нийслэлийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн үнэлгээг энэ журмын 4 дүгээр хавсралтын дагуу гаргана.

58. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх Үндсэн чиглэл, үндэсний хөтөлбөр, төсөл зэрэг баримт бичгээр дамжин хэрэгжиж байгаа төрийн бодлого иргэдийн амьдралд ямар үр нөлөө үзүүлснийг эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн биелэлт болон Хэрэглэгчийн үнэлгээгээр (түүвэр, судалгааны дагуу) үнэлнэ.

59. Хэрэглэгчийн үнэлгээг төрийн бодлогын хэрэгжилт, төрийн байгууллагуудаас иргэдэд үзүүлж байгаа үйлчилгээний чанар, хүртээмжийн талаар тухайн аймаг, нийслэл, сум, дүүргийн насанд хүрсэн иргэдийн 3-5 хүртэлх хувийг эсхүл аж ахуйн нэгжүүдийг хамруулан явуулсан санал асуулгын дүнг үндэслэн гаргах бөгөөд уг үнэлгээг шууд хэрэглэнэ.

60. Хэрэглэгчийн үнэлгээг судалгаа, хяналт-шинжилгээ, үнэлгээний чиглэлээр ажилладаг мэргэжлийн болон төрийн бус байгууллагаас ажлын туршлага, хүний нөөцийн хүчин чадал зэргийг харгалзан сонгон шалгаруулж хийлгэнэ. Тэдгээр

байгууллагыг сонгох ажиллагааг тухайн үнэлгээ хийлгэх байгууллага зохион байгуулна.

61. Авлигатай тэмцэх газраас гаргасан “Байгууллагын шударга байдлын түвшингийн үнэлгээ” нь төрийн захиргааны байгууллагын үнэлгээний нэг үзүүлэлт болно.

62. Бодлогын зорилтын хэрэгжилтийн түвшинг тодорхойлохдоо тавьсан зорилтын гүйцэтгэл тогтоох шалгуур үзүүлэлтийн үр дүнг (Г) хүрэх түвшин буюу тавьсан зорилтод (З) харьцуулж хувиар илэрхийлнэ (Г/Зx100).

63. Тоогоор илэрхийлж үнэлэх боломжгүй зорилтын шалгуур үзүүлэлтийн биелэлтийн хувийг тодорхойлоход дараах зарчмыг баримтална. Үүнд:

-тавьсан зорилтдоо бүрэн хүрсэн, энэ талаар холбогдох шийдвэр гарч, үр дүн гарсан бол 100 хувь;

-тавьсан зорилтдоо бүрэн хүрээгүй боловч санхүү, зохион байгуулалтын арга хэмжээ бүрэн авагдсан, холбогдох байгууллагын шийдвэр гарсан, гол үр дүн нь гарч эхэлж байгаа бол 90.0 хувь (80.0-100.0 хүртэл хувь);

-тавьсан зорилтод хүрэх зорилгоор өөрсдөөс хамаарах шийдвэрийг гаргасан, санхүүгийн асуудал шийдвэрлэгдсэн, дээд шатны байгууллагад өргөн барьсан буюу гүйцэтгэл нь тодорхой хэмжээгээр гарч эхэлж байгаа бол гүйцэтгэлийн байдлыг харгалзан 70.0 хувь (60.0-80.0 хүртэл хувь);

-тухайн зорилтыг хэрэгжүүлэх бэлтгэл болон боловсруулалтын шатны ажил бүрэн хийгдсэн, ажил тодорхой хэмжээнд эхэлсэн бол хийгдэж байгаа ажлын түвшинг харгалзан 50.0 хувь (40.0-60.0 хүртэл хувь);

-тухайн зорилтыг хэрэгжүүлэх бэлтгэл ажил хийгдэж дуусаад боловсруулалтын шатанд байгаа бол хийгдэж байгаа ажлын түвшинг харгалзан 30.0 хувь (20.0-40.0 хүртэл хувь);

-тухайн зорилтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай тооцоо, судалгаа хийх, асуудал тодорхойлох зэрэг бэлтгэл хангахтай холбогдсон арга хэмжээг авч эхэлж байгаа бол ажлын түвшинг харгалзан 10.0 хувь (0-20.0 хүртэл хувь);

-тухайн зорилтыг хэрэгжүүлэх талаар ямар нэгэн ажил зохион байгуулаагүй бол биелэлтийн хувийг “0” гэж үзнэ.

64. Энэ журмын 2, 3 дугаар хавсралт дахь үнэлгээний оноог гаргахдаа тухайн үнэлгээний хувийг 0.05-аар үржүүлж, ерөнхий үнэлгээг гаргахдаа нийт онооны нийлбэрийг үнэлгээний тоогоор хуваана.

65. Хяналт-шинжилгээ хийх, үнэлгээ өгөх бодлого, хөтөлбөр, төсөл нь хэд хэдэн салбарыг хамарсан эсхүл нарийн мэргэжлийн ур чадвар, туршлага шаардаж байвал тухайн салбарын эрдэм шинжилгээ, судалгааны болон мэргэшсэн байгууллага, төрийн бус байгууллагын төлөөлөл бүхий багаар хяналт-шинжилгээ, үнэлгээг гэрээний дагуу гүйцэтгүүлж болно.

Ес. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүнг хэрэгжүүлэх

66. Захиргааны байгууллага нь хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнтэй холбогдуулан “Гүйцэтгэл сайжруулах төлөвлөгөө”-г баталж, дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ:

66.1. Яам, Засгийн газрын агентлаг, гадаад, дотоодын ижил үйл ажиллагаа явуулдаг байгууллага, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын тэргүүний арга, туршлагыг түгээн дэлгэрүүлэх, гарсан алдаа, гажуудлыг засах;

66.2. Байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх чиглэлээр сургалт зохион байгуулах;

66.3. Яам, аймаг, нийслэлийн Засаг даргад үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх талаар үүрэг, чиглэл өгөх, шаардлагатай тохиолдолд зохих удирдамжийн дагуу газар дээр нь шалгалт хийж, дүгнэлт гаргах;

66.4. Яам, Засгийн газрын агентлаг, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын тэргүүний арга, туршлагыг цахим хуудсаар болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтийн хүртээл болгох.

67. Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын үнэлгээг эдийн засгийн чадамж, дэд бүтцийн хөгжил, хүн амын тоо, газар зүйн байршил, цаг уурын бүсчлэл зэргийг харгалзан дараах хэсэгт хуваан гаргах бөгөөд хэсэг тус бүрээс нэг аймгийг шалгаруулан урамшуулна. Үүнд:

1	2	3	4	5
Нийслэл	Баян-Өлгий	Архангай	Дорнод	Булган
Дархан-Уул	Говь-Алтай	Баянхонгор	Сүхбаатар	Өмнөговь
Орхон	Увс	Өвөрхангай	Дундговь	Дорноговь
Ховд	Хөвсгөл		Хэнтий	Сэлэнгэ
Завхан	Говьсүмбэр	Төв		

68. Засгийн газар ерөнхий үнэлгээгээр хамгийн өндөр оноо авсан таван аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газарт тус бүр 20.0 сая хүртэл, шалгарсан аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дарга тус бүрт хүртэл сарын үндсэн цалинтай нь тэнцэх мөнгөн урамшуулал олгоно.

69. Урамшуулалд зарцуулах хөрөнгийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын төсөвт жил бүр тусгана.

70. Захиргааны байгууллага нь хяналт-шинжилгээ, үнэлгээг газар дээр нь хийх, эрдэмтэн, судлаачдыг татан оролцуулах, Хэрэглэгчийн болон хөндлөнгийн үнэлгээ хийлгэх, ХШҮ-ний сургалт зохион байгуулах, сургалтын материал, ном, товхимол, гарын авлага хэвлүүлэх зэрэг зардлыг захиргааны байгууллагын жил бүрийн төсөвт тусгана.

-- о О о --

**ХОЛБОГДОХ ЭРХ ЗҮЙН АКТЫН БОЛОН БОДЛОГЫН
БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ТАЙЛАГНАХ ХУГАЦАА**

№	Тайлангийн төрөл	Тайлан гаргах байгууллага	Тайлан хүлээн авах байгууллага	Хугацаа (сар, өдөр)	Засгийн газрын хуралдаанд оруулах хугацаа
1.	Холбогдох эрх зүйн актын биелэлт	Төрийн өмчит хуулийн этгээд, Улсын төсөвт үйлдвэрийн газар	Салбарын яам болон ЗГ-ын агентлаг	01.05 06.20	2 дугаар сар, 8 дугаар сар
		Аймаг, нийслэлийн Засаг дарга	ЗГХЭГ	01.10 07.10	
		Засгийн газрын агентлаг	Яам, Ерөнхий сайд болон Шадар сайдын ажлын алба	01.05 07.01	
		Яам	ЗГХЭГ	01.15 07.10	
2.	Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогын биелэлт	Аймаг, нийслэлийн Засаг дарга	ЭЗХЯ	02.01	3 дугаар сар
		Засгийн газрын агентлаг	Яам, Ерөнхий сайд болон Шадар сайдын ажлын алба	12.20	
		Яам, Ерөнхий	ЭЗХЯ	02.01	

		сайд, Шадар сайдын ажлын алба			
3.	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлт	Төрийн өмчит хуулийн этгээд, Улсын төсөвт үйлдвэрийн газар	Салбарын яам болон ЗГ-ын агентлаг	06.05 12.10	3 дугаар сар, 8 дугаар сар
		Засгийн газрын агентлаг	Яам, Ерөнхий сайд болон Шадар сайдын ажлын алба	06.15 12.20	
		Яам	ЗГХЭГ	02.01 07.10	
4.	Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт	Төрийн өмчит хуулийн этгээд, Улсын төсөвт үйлдвэрийн газар	Салбарын яам болон ЗГ-ын агентлаг	06.20 12.20	3 дугаар сар, 9 дүгээр сар
		Засгийн газрын агентлаг	Яам, Ерөнхий сайд болон Шадар сайдын ажлын алба	01.05 07.01	
		Яам, Ерөнхий сайд, Шадар сайдын ажлын алба, ЗГХЭГ	ЭЗХЯ	02.01 07.10	
5.	Үндэсний хөтөлбөрийн биелэлт	Төрийн өмчит хуулийн этгээд, Улсын төсөвт үйлдвэрийн газар	Салбарын яам болон агентлаг	12.20	4 дүгээр сар

		Засгийн газрын агентлаг	Яам, Ерөнхий сайд болон Шадар сайдын ажлын алба	01.20	
		Аймаг, нийслэлийн Засаг дарга	Холбогдох яам	02.10	
		Яам	ЗГХЭГ	04.01	
6.	Улсын төсөв, гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж байгаа төслийн хэрэгжилт	Төрийн өмчит хуулийн этгээд, Улсын төсөвт үйлдвэрийн газар	Салбарын яам болон ЗГ-ын агентлаг	12.20	4 дүгээр сар
		Засгийн газрын агентлаг	Яам, Ерөнхий сайд болон Шадар сайдын ажлын алба	01.20	
		Аймаг, нийслэлийн Засаг дарга	Холбогдох яам	02.10	
		Яам	ЗГХЭГ	04.01	
7.	Тухайн жилийн үйл ажиллагааны хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан	Засгийн газрын агентлаг	Яам, Ерөнхий сайд болон Шадар сайдын ажлын алба	02.01	6 дугаар сар
		Аймаг, нийслэлийн Засаг дарга	ЗГХЭГ	04.01	
		Яам	ЗГХЭГ	04.01	
8.	Байгууллагын сар бүрийн үйл ажиллагааны мэдээлэл	Яам	ЗГХЭГ	Дараа сарын 5	Дараа сарын 15-ны дотор

ЯАМНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНЭЛГЭЭНИЙ ДҮН

(... оны үйл ажиллагааны үр дүн)

		Үр дүнгийн үнэлгээ	
		Хувь	Оноо
Бодлогын зорилтын хэрэгжилтийн үр дүнгийн үнэлгээ	1. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт		
	2. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх Үндсэн чиглэлийн биелэлт		
	3. Улсын Их Хурлын тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж, Засгийн газрын шийдвэрийн биелэлт		
	4. Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогын хэрэгжилт		
	5. УИХ, Засгийн газраас баталсан Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт		
	6. Улсын төсөв болон гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа төслүүдийн хэрэгжилт		
Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ	1. Төсвийн ерөнхийлөн захирагчаас төсвийн шууд захирагчтай байгуулсан үр дүнгийн гэрээний биелэлт		
	2. Байгууллагын тухайн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт		
	3. Гүйцэтгэл сайжруулах төлөвлөгөөний биелэлт		
Байгууллагын нээлттэй байдлын үнэлгээ	1. Байгууллагын ил тод байдлын үнэлгээ		

үнэлгээ	2. Байгууллагын шударга байдлын түвшний үнэлгээ		
Үйл ажиллагааны үр дагаврын үнэлгээ	1. Засаглалын болон эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн үнэлгээ		
	2. Хэрэглэгчийн үнэлгээ		
Ерөнхий үнэлгээ			